



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/186

Ховд

Зарим үйлчилгээний байгууллагуудад цагийн
хязгаарлалт тогтоож, зарим үйлчилгээг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “в”, 29.1.6-ын “а”, “ж”, “л” заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын хуралдааны 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 20 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинэ коронавирус /сovid-19/-ийн халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үйлчилгээний байгууллагуудын ресторан, кафе, зоогийн газруудыг 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд архи, согтууруулах ундаагаар үйлчлэхийг хориглож, 10.00-20.00 цагийн хооронд хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байхаар цагийн хуваарийг тогтоосугай.

2.Захирамжийг олон нийтэд мэдээлж, сурталчлан, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ